

БАТЛАВ:
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Б.СУГАР



НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**“ЯВУУЛЫН ИРГЭНИЙ ТАНХИМ” ХУДАЛДАН АВАХ АЖ АХУИН
НЭГЖИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИИН
БАРИМТ БИЧИГ**

НАРИЙНТЭЭЛ СУМ

2019 -он

НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**“ЯВУУЛЫН ИРГЭНИЙ ТАНХИМ” ХУДАЛДАХ АВАХ ҮНИЙН
САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: *“Явуулын иргэний танхим” худалдан авах*

Төслийн дугаар: **ӨВАНТСЗДТГ /201901004**

**Харьцуулалт/
гэрээний дугаар:** **Харьцуулалтын аргаар**

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

1. Нарийнтээл Сумын Засаг Даргын Тамгын Газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос Сумын **“Явуулын иргэний танхим”** (машин) худалдан авахыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендер шалгаруулалтын Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан "Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам"-ын дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50.000 /тавин мянга/** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

2. Үнийн саналыг **2019 оны 11 дүгээр сарын 15-ны 10 цаг 00** минутаас өмнө Сумын Засаг Даргын Тамгын газрын 2-давхар мэдээллийн танхимд **“Үнэлгээний хороонд”** гэсэн хаягаар ирүүлнэ.

2. Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 10 цаг 50** минутад нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорхи хаягаар авч болно.

**Нарийнтээл Сумын Засаг Даргын Тамгын Газар 89967792
88050400
99226106
86118778**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | | |
|---|-------------|--|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. | Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйлд заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| | | Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 3. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 3.1. | Нийлүүлэх бараа нь энд заасан техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд үүнийг заавал мэдэгдэнэ. |
| | 3.2. | Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг батлах үүрэгтэй. |
| 4. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 4.1. | Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| 5. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 5.1. | Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ. |
| | 5.2. | Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| | 5.3. | Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна. |
| 6. Гэрээ байгуулах | 6. | |

Гурав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|---|-------------|---|
| 1. Шалгах болон турши | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж |

3. **Оюуны өмчийн эрх** бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.

4. **Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх** ээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (^COTERM3) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.

5. **Баталгаат засварын хугацаа** тдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа байна.

6. **Гэрээнд өөрчлөлт оруулах** эрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.

7. **Бараа нийлүүлэх хуваарь** йлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.

8. **Алданги оногдуулах** иалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.

9. **Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах** йлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.

10. **Маргааныг шийдвэрлэх** Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Дөрөв. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|--|
| 1. Шалгах болон турших (ГЕН - 1) | 1.1 Захиалагч нийлүүлэх бараа бүтээгдэхүүнийг техникийн тодорхойлод заасан шаардлагыг хангаж буй эсэхийг шалгана.
Барааг захиалагчид нийлүүлэхээс өмнө нийлүүлэгчийн |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН - 2) | 2.1 Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:

1) Тээврийн хэрэгслийн бичиг баримт
2) Барааг хүргэсэн тухай баримт, тээврийн баримт;
3) Гаалийн үнэлгээ 3.0 В буюу түүнээс дээш

Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.

Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Захиалагч барааны төлбөрийн нэхэмжлэл хүлээн авсанаас хойш ажлын 7 хоногийн дотор багтаан сар бүр шилжүүлнэ. |
| 3. | |
| 4. Төлбөр (ГЕН - 3) | |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 11) | 11.1 Алданги оногдуулах хувь:

Алдангийн нийт дүн: |

Гурав.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>ААНэгж</p> <ul style="list-style-type: none"> - Сүүлийн 1 /нэг/ жилийн буюу 2018 оны санхүүгийн тайлан - Ижил төстэй ажил гүйцэтгэсэн сүүлийн 2 жилийн туршлагын мэдээлэл. Сүүлийн 2 жил буюу /2017, 2018/ оны аль нэг жилд ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагатай байх /гэрээний хуулбар/ <p style="text-align: center;"><u>Бусад нэмэлт шаардлага:</u></p> <ul style="list-style-type: none"> - Харилцагч банкуудын хугацаа хэтэрсэн өр, зээлгүй тодорхойлолт -Татвар, Нийгмийн даатгалын байгууллагын өр төлбөргүй болох тодорхойлолт - Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар -Банкнаас зээл авах зээлийн хэмжээг тодорхойлсон тодорхойлолт <p>Иргэн</p> <ul style="list-style-type: none"> - Харилцагч банкуудын хугацаа хэтэрсэн өр, зээлгүй тодорхойлолт - Татвар, нийгмийн даатгалын байгууллагын өр төлбөргүй болох тодорхойлолт - Иргэний үнэмлэхний хуулбар
Байгууллагын	<p>Тендерт оролцогч нь:</p> <ol style="list-style-type: none"> 1. Тендерт оролцогч нь боловсруулсан тендерийн иж бүрдэл, баримт бичгийг электрон хэлбэр /Adobe PDF/-т хөрвүүлж цахим хэлбэрээр ирүүлнэ. 2. Захиалагч шалгарсан тендерт оролцогчийн талаар санхүүгийн болон бусад мэдээллийг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл ирүүлэх <p>Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь:</p> <p>Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Засаг Даргын Тамгын газар. Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь төрийн худалдан авах ажиллагааны систем /www.tender.gov.mn/-д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэг (PK1)-ээр нэвтрэн орж материалыг цахимаар авч, тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: Нарийнтээл сум Цагаан-овоо баг Засаг Даргын Тамгын газар, 2-р давхарт "Мэдээлийн танхим"-д</p> <p>Огноо: 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минуут</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn -ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийг хүлээн авах боломжгүй.</p>

	тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Нарийнтээл сумын Засаг даргын Тамгын газар</p> <p>Давхар болон өрөөний дугаар 2 -р давхарын Мэдээллийн танхим Үнэлгээний хороонд.</p> <p>Огноо: 2019 оны 11 дүгээр сарын 15- ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 50 минут.</p>
ТӨӨЗ 6.1	Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Тав. ТЕХНИКИЙН ТОДОРХОИЛОЛТ

1. **Барааны тодорхойлолт:** Нарийнтээл сумын ИТХуралд “Явуулын иргэний танхим” худалдан авах

2. **Стандарт:** Үйлдвэрлэсэн улс: Солонгос улсад үйлдвэрлэсэнтэй дүйцэхүйц

Марк: Hyundai starex дүйцэхүйц

Үйлдвэрлэсэн он: 2006-2007 оноос

Монгол улсад орж ирсэн он: 2018-2019 оноос

Моторын багтаамж: 2.5-аас дээш

Хөдөлгүүр: Дизель

Хурдны хайрцаг: Автомат, механик

Хөтлөгч: 4WD хүндрүүлэгчтэй

Дугуйн хэмжээ: 15

Монгол улсад орж ирээд яваагүй

Сэв замаскгүй

Суудлын тоо: 12

Зориулалт: Суудлын

Тээврийн хэрэгслийн бичиг баримтыг захиалагч байгууллагын нэр дээр шилжүүлсэн байх.

Бараа хүргэх газар: Нарийнтээл сумын Цагаан-Овоо 4-р баг “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал”

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг **[санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр]** төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад

Тендерт оролцогчийн нэр: _____

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга

Албан тушаал, нэр: _____

Хаяг: _____

2. ГЭРЭЭНИИ МАЯГТ¹

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож оны ____ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]-г** (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны ____ дугаар сарын ____ -наас _____ оны ____ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг²;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт

¹ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

² Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, еерчлелтүүд.

бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]